“ХАТГАХ, ТӨӨНӨХ ТЭРГҮҮТНИЙГ ХУРААСАН НОМ ДЭВТЭР БҮТЭЭЛ”-ИЙН ЦАГ ХУГАЦААГ ТОГТООХ НЬ

Б.Хулан[1], Д.Шагдарсүрэн[1], Х.Улаан-Од[2], Ш.Болд[1,2,3]
[1]ЭЗШУИС, [2]“Ач” АУИС, [3]МАУА
E-mail: tuudu192924@gmail.com

Abstract

DETERMINING TRANSLATED TIME OF THE “COMPENDIUM ON ACUPUNCTURE AND MOXIBUSTION”

Khulan.B[1], Shagdarsuren.D[1], Ulaan-Od.Kh[2], Bold.Sh[1,2,3]
[1]Mongolian University of Pharmaceutical Sciences
[2]”Ach” Medical University, 3Mongolian Academy of Medical Sciences
E-mail: tuudu192924@gmail.com

It is evident that the book “Compendium on Acupuncture and Moxibustion” was not translated until 1757. It may have been translated since 1757. Evidence of this is the School of Clear Script was established in the 47th year of Tengeriig Tetgegch Khan or in 1782 in Beijing. Therefore, we suggest that Zhenjiu Dacheng 针 灸 大成 was written in 1601 by Yang Jizhou 杨继 州 and translated into Mongolian in Clear Mongolian script in 1782. It is reasonable to believe that this written translation of the “ Compendium on Acupuncture and Moxibustion “ book spread in western Mongolia from this period. However, today only the 4th and 6th books of the 10 books of this book have been handed down to us.

The first period for the Clear Script developed from 1648 to the second half of the XVIII century, but it did not reflect the Oirat local dialect. The second period covered from the second half of the XVIII century to the recent Xinjiang. In this period Oirat’s local dialect was reflected in the Clear Script. Also, one interesting fact is that there are a lot of Oirat local dialects in the Mongolian translation of the “Compendium on Acupuncture and Moxibustion”.

Therefore, the book is being translated into the late XVIII century or after the second half of the XVIII century.

Keywords: Clear Script, Zhenjiu Dacheng, Oirat dialect, Mongolian translation

Үндэслэл

Хятадын зүү, төөнө заслын эмчилгээний арга Янг Жи Зоү-гийн 1601 онд зохиосон ”Zhen Jui Da Cheng”, (Хатгуур, төөнө тэргүүтнийг ихэд хураасан ном, дэвтэр буюу англиар Compendium on Acupuncture and Moxibustion) бүтээлээр дамжин Баруун Монголд дэлгэрчээ. Ойрадын Заяа бандида Намхайжамцын шавь нар, хойч үе нь хятад хэлнээс тод монгол үсгээр “Хатгах төөнөх тэргүүтнийг хураасан ном, дэвтэр” нэрээр орчуулсан байна.

Профессор Н.Төмөрбаатар 1999 онд уг бүтээлийн монгол орчуулгыг хятад эмнэлгийн зүү, төөнийн бусад зохиолуудтай харьцуулан судалж тусгай өгүүлэл нийтлүүлсэн билээ [1].

Тод үсгийн баялаг өвтэй үндэстэн Халимагт ”Хатгах, төөнөх тэргүүтнийг хураасан ном, дэвтэр” зохиолыг 1977 оноос судлан орос хэлэнд орчуулан 1986 онд ”Трактаты об иглоукалывании и прижигании” нэрээр хэвлүүлжээ [2].

Заяа бандид 1648 онд Тод үсгийг зохиож өөрөө болон түүний шавь нар тод үсгийг бүх монголчуудын үсэг болгох зорилгоор тухайн үеийн Монголын нийгэмд гол нөлөө үзүүлж байсан Буддын шашин түүнтэй холбоотой мэдлэг ухааны бусад дорвитой бүтээлүүдийг төвөд хэлнээс монгол хэлээр орчуулснаас гадна Хятадын анагаах ухааны зүү, төөнө заслын зохиолуудаас сорчлон авч орчуулжээ. Хятадын анагаах ухааны зүү, төөнийн нэр, нөлөө бүхий зохиолыг монгол хэлэнд орчуулснаараа энэ чиглэлийн цоо шинэ онол, ойлголт, урсгалыг бий болгох эхлэлийг тавьжээ.

Зорилго

“Хатгах, төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр бүтээл”-ийн орчуулагдсан цаг хугацааг урьд, хожмын судалгаанд тулгуурлан тодруулах

Судалгааны арга

1/ Сурвалж бичгийн судлалын арга

Судалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ цаг хугацааны дараалалд оруулан өөр бусад бүтээлүүдийн мэдээллээр баяжуулан оюун дүгнэлт хийлээ. Үүнд тодорхой нэг уламжлалт түүхийн (ном зүй, эх бичиг) жишээн дээр тулгуурлан мэдлэгийн трансформацийн зүй тогтлыг илрүүлэх арга М.Отгонбаяр (1995), уламжлал шинэчлэлийн асуудалд диалектик зүй тогтлын үүднээс хандах арга Л.Н Гумилев (1989), Н.Хавх (1995), он дараалаар жишиж, шууд ба урвуу хамаарал, холбоо уялдааг нягтлах арга (Г.Сүхбаатар 2002)-уудыг хэрэглэв [3].

2/ Харьцуулалтын арга [4]

Уламжлалт анагаах ухааны янз бүрийн үед болсон үйл явдлуудыг төрөлжүүлэн хувааж хооронд нь харьцуулах, эмчилгээний онол, арга зүй нэг үе шатнаас нөгөөд хэрхэн уламжлан дамжиж ирснийг илрүүлэхэд энэхүү аргыг хэрэглэлээ.

Судалгааны ажлын үр дүн, хэлцэмж

“Хатгах, төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр бүтээл”-ийн үндсэн агуулга нь хятад хэлнээс орчуулагдсан гэдэг нь олон талаасаа батлагдаж байна. Гэхдээ уг номыг бичигдэхээсээ өмнө дорно дахинд Хятадын анагаах ухааны хөгжилд хүчтэй нөлөө үзүүлж байсан зүү, төөнийн эмчилгээний аргын талаар хэд хэдэн бүтээл хэвлэгдэж гарсан байжээ. Тухайлбал: Ванг-Бинг (Wang Bing) “Хуанди Нэйжин”-ий “Сүвэн”-ий 762 оны эмхэтгэл, Занг Зи-Хэ “Ru Men Shi Qin” (1228), Хутай Билиг “Jinlan Xunjing Quxue Tujie” Golden Orchids through the acupoints’ diagram (1303) [5], Хуа Шоу (Hua Shou) “Shi Si Jing Fa Hui” (1341), Зу Зэн-Хэнг (Zhu Zhen-Heng) “Dan Xi Xin Fa” (1347) зэрэг олон бүтээлүүд гарсан байна. Эдгээр бүтээлээр дамжуулан өөрийн орны анагаах ухааны хөгжлийг шинэ түвшинд гаргахыг тэр үеийн Монголын шилдэг сэхээтнүүд бодохгүй, оролдохгүй байна гэх үндэсгүй юм.

“Хатгах, төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр бүтээл”-ийг чухам хэдий үед орчуулсныг тодорхой болгосон судалгааны ажил алга байна. Гэхдээ таамаг дэвшүүлсэн эрдэмтэд байна. Тухайлбал: Халимагийн эрдэмтэн П.Ц.Биткеев: 18 дугаар зууны Ойрадын эрдэмтдийн “Трактаты об иглоукалывании и прижигании” бүтээл нь 7 боть бөгөөд зөвхөн 2 боть нь ... гэж [6] тэмдэглэсэн байна. Профессор Н.Төмөрбаатар: “Зүү төөнө заслын энэ номын уг гарвалыг судалж үзэхэд Ming улсын судлаач эмч Yang Jizhou 杨继州 1601 онд бичсэн Zhenjiu Dacheng 针 灸大成 (Зүү төөнө заслыг их хураасан ном) хэмээх бүтээлийг Баруун Монголд орчуулан монголчилж, ойрад монгол аялгуугаар ойролцоогоор 1660 оны үед буулгасан гэж үзжээ. Учир нь нанхиад эрдэмтэн Yang Jizhou уг номыг бичсэнээс хойш 47 жилийн дараа 1648 онд Ойрадын Заяа бандида Намхайжамц тод үсэг зохиож, ном бичиж эхэлсэн ...” хэмээжээ. Харин Академич Ш.Болд “Заяа бандида Намхайжамц 1650-1662 оны хооронд “Анагаах ухааны дөрвөн үндэс” 4 боть номыг орчуулжээ. Үүнээс “Язгуурын үндэс”, ”Хойд үндэс” хоёр нь Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт байгаа юм. “Язгуурын үндэс” 6 бүлэгтэй, ”Номлохуйн үндэс” 31 бүлэгтэй, ”Увдисын үндэс” 92 бүлэгтэй ”Хойд үндэс” 25 бүлэгтэй бүгд 156 бүлэгтэй. Бидэнд одоо 31 бүлэг нь тод үсгээр олдоод байна. Бас “Язгуурын үндэс”-ээс хэсэглэн авсан өөр нэг орчуулга байгааг Чойжиндаш гэдэг хүний дурдсанаар орчуулжээ. Нөгөө талаар “Хойд үндэс”-ийг Зүүнгарын Галданцэрэнгийн үед буюу 1741-1742 оны орчим барлажээ. Мөн хятад хэлнээс орчуулсан “Хатгах төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр” номын 4, 6 дугаар дэвтэр буй. Дөрөвдүгээр дэвтэр нь 81 хуудастай 18 зурагтай. Зургаадугаар дэвтэр нь 128 хуудастай 11 зурагтай” гэжээ [7]. Тиймээс Академич Ш.Болд уг номыг “Хойд үндэс”-ийг Галданцэрэнгийн үед буюу 1741-1742 онд барласнаас хойш орчуулсан гэсэн санааг гаргасан байна. Эдгээр эрдэмтдийн таамаглалыг дараах байдлаар харьцуулан авч үзэв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. “Хатгах төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр” бүтээлийн бичигдсэн цаг хугацааг харьцуулсан нь

Эрдэмтдийн нэр, таамаглал		
Халимагийн эрдэмтэн П.Ц.Биткеев	Профессор Н.Төмөрбаатар	Академич Ш.Болд
Ойрадын эрдэмтдийн “Трактаты об иглоукалывании и прижигании” бүтээл нь 18 дугаар зуунд бичигдсэн	Ойрад монгол аялгаар ойролцоогоор 1660 оны үед буулгасан гэж үзэж байна	1741-1742 оны орчим барласан “Хойд үндэс”-ийн дараа орчуулсан

Бид сүүлийн үед хийсэн судалгааны явцад арай өөр санал дэвшүүлж байна. Заяа Бандида 1648 онд тод үсгийг зохиосноороо утга зохиолд төдийгүй Монголын анагаах ухааны хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулсан гавъяатай хүн. Түүний зохиосон үсэг дээрх тод үсгийн дурсгалыг хоёр үед хуваадаг. Үүнд: Нэгдүгээр үе нь 1648 оноос XVIII зууны 2-р хагас хүртэл, хоёрдугаар үе нь XVIII зууны 2-р хагасаас Халимагт 1924 он хүртэл, Шинжаанд одоо хүртэл гэж тус тус үечилдэг. Түүний намтар ”Сарны гэрэл”-д Заяа бандидын өөрийн нь орчуулсан 178 ном [8], гурван шавийн нь нэмж орчуулсан 37 номын нэр байна. Заяа бандидын орчуулга хийж байсан үе бол 1648-1662 он гэж үзэх бүрэн үндэстэй байна. Энэ цаг үеийн орчуулгын бүтээлийн нэрийн жагсаалтад хятад хэлнээс орчуулсан ном байхгүй нь тодорхой ажгуу. Түүнчлэн тод үсгийн дурсгалын нэгдүгээр үе, 1648 оноос XVIII зууны 2-р хагас хүртэл хугацааны 1662 он буюу Заяа бандидааг тэнгэрт халих хүртэл зөвхөн төвөд хэлнээс орчуулга хийгджээ.

Академич Ринчин өөрийнхөө зохиолуудад тод монгол барын номын тухай онцлон тэмдэглэсний дотроос “Нангиадаас орчуулсан ойрадын орчуулга” гэдэг өгүүлэлд тод монгол барын ном 7 буюу 8 байгаа нь мэдэгдэж байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь Манжийн үеэс өмнөх үед холбогдоно гэжээ [9]. Энэ хугацааг Ойрадууд Манжид эзлэгдсэн 1757 оноос өмнө гэж үзвэл ямарч байсан хятадаас орчуулсан цөөн бус зохиол бий аж. Гэхдээ эдгээр зохиолд “Хатгах, төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр бүтээл” байсан гэдэг мэдээ алга аа. Тиймээс энэ бүтээлийг 1757 оноос өмнө орчуулсан гэх баталгаа нотлогдохгүй нь илэрхий. 1757 оноос хойш орчуулагдсан байж болох талтай. Үүнийг нотлох баримт нь Манжийн Тэнгэр тэтгэгчийн 47-р он буюу 1782 онд Бээжинд Тод үсгийн сургууль байгуулжээ. Тод үсгийн сургууль байгуулах болсон зорилго нь Зүүнгарыг эзэлсний дараа Ойрадаас ирсэн бичиг харыг уншиж таних хүн цөөхөн байсантай холбоотой. 1797 онд Фу Жун “Монгол тод үсгээр нийлэлдүүлсэн цуглуулга” гэж толь бичиг зохиожээ [9]. Тиймээс Yang Jizhou 杨继州 1601 онд бичсэн Zhenjiu Dacheng 针 灸大成 номыг 1782 оноос хойш орчуулсан байж болох юм гэсэн санааг бид дэвшүүлж байна. Учир нь:

1. Yang Jizhou 杨继州 1601 онд бичсэн Zhenjiu Dacheng 针 灸大成 ном 10 боть тиймээс хятад хэлэнд ихэд боловсорсон үед буюу Бээжинд тод үсгийн сургууль байгуулсан цагаас хойш.
2. Хятад хэлнээс Манжийн үеэс өмнө орчуулсан тод монгол барын номонд “Хатгах, төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр бүтээл” байхгүй.
3. Тод үсгийн хөгжлийн нэгдүгээр үе 1648 оноос XVIII зууны 2-р хагас хүртэл хугацаанд ойрад аялгууны онцлог тусгагдаагүй бөгөөд харин хоёрдугаар үе XVIII зууны 2-р хагасаас Шинжаанд одоо хүртэл хэрэглэж буй тод бичигт Шинжааны ойрад аялгуу тусгагджээ. “Хатгах, төөнөх тэргүүтнийг хураасан ном дэвтэр бүтээл”-д ойрад аялгуу ихэд тусгагдсан байдаг.

Ном зүй

1. Төмөрбаатар Н. Тод үсгээр бичигдсэн зүү төөнө заслын нэгэн ном. ”Заяаа Бандиди Намхайжамц” эрдэм шинжилгээний илтгэлийн хураангуй. УБ, 1999, х. 106-110
2. Трактаты об иглоукалывании и прижигании. (Научный руководитель перевода и ответственный редактор П.Ц.Биткеев). Издательство “Наука” Главная редакция восточной литературы, Москва, 1987
3. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. УБ, 2006. х.26
4. Charles C. Ragin. The Comparative Method: Moving Beyond Qualitative and Quantitative Strategies. University of California Press, 1987. p. 12-16

5. Mario Schwarz. Tai Chi Chuan: transformaciyn y cambio para lograr el bienestar. Argentia, 2008. p. 47
6. Трактаты об иглоукалывании и прижигании. (Научный руководитель перевода и ответственный редактор П.Ц.Биткеев). Издательство “Наука” Главная редакция восточной литературы, Москва, 1987, стр 6-7
7. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Дөтгөөр боть. УБ, 2013. х.149-150
8. Батмөнх Б. Заяа бандида: Огторгуйн Далай. Улаанбаатар, 2018, х.48
9. Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ, 1975
10. Батмөнх Б. Заяа бандида: Огторгуйн Далай. Улаанбаатар, 2018, х.104